



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/132

Номгон

“Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн
удирдлагын болон хэрэгжүүлэгч багийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/а заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах санамж бичиг, Улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн удирдлагын багийг 1 дүгээр, хэрэгжүүлэгч багийг 2 дугаар, “Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах нь” төслийн хэрэгжүүлэгч багийг 3 дугаар, “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн хэрэгжүүлэгч багийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. НҮБ-ын Хүүхдийн сантай байгуулсан гэрээний биелэлтийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулан хангаж, төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг удирдлагын болон хэрэгжүүлэгч багийн дарга (Б.Батсуурь, Г.Энхбаяр, М.Өнөржаргал, Д.Энхжаргал) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Төртогтох)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын “Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн Зохицуулах багийг томилсон 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/297, “Эх хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах нь” төслийн хэрэгжүүлэгч багийг томилсон Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/131, “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төслийн хэрэгжүүлэгч багийг томилсон 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/847 тоот захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210352

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын
23-ны өдрийн А/132 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ ХӨТӨЛБӨР”-ИЙН УДИРДЛАГЫН БАГ


Аймгийн Засаг даргын Хөдөө аж ахуй, дэд бүтцийн асуудал хариуцсан
орлогч дарга

Аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар
хариуцсан орлогч дарга


Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах
мэргэжилтэн



Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын
23-ны өдрийн А/132 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт



**“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ ХӨТӨЛБӨР”-ИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн
дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн
дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засаг, стратеги төлөвлөлт, хөрөнгө оруулалт
хариуцсан мэргэжилтэн

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын
байцаагч, хүүхдийн эрх, хөгжил хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн


Эрүүл мэндийн газрын хүүхдийн ерөнхий мэргэжилтэн

Боловсрол, соёл, урлагийн газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн

Цагдаагийн газрын Хүүхдийн байцаагч

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн хүүхэд, залуучууд, гэр бүл, жөндөрийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын
23-ны өдрийн А/132 дугаар захирамжийн
3 дугаар хэвсрэлт



**“ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД АГААРЫН БОХИРДЛЫН
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ НЬ” ТӨСЛИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАГ**

Дарга: Аймгийн Засаг даргын Хөдөө аж ахуй, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч дарга

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

Баянхонгор сумын Засаг дарга

Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Ус,цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүн


Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-ний ерөнхий инженер

4-р багийн иргэний төлөөлөл /эрэгтэй/

5-р багийн иргэний төлөөлөл /эмэгтэй/

Нарийн бичгийн дарга: Баянхонгор сумын орлогч дарга

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын
23-ны өдрийн А/132 дугаар захирамжийн
4 дүгээр хавсралт



**“ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВЭР,
ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
БАГ**

Дарга: Аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар
хариуцсан орлогч дарга

Гишүүд -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга

Мэргэжлийн хяналтын газрын орчны Эрүүл ахуй, халдвар хамгааллын
хяналтын улсын байцаагч

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын
байцаагч

Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын
кадастр, зураг төсөл, магадлал хариуцсан мэргэжилтэн

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн усны инженер

“Чандмань Баянхонгор” ХК-ний ерөнхий инженер

Мөнххэвлий ус ашиглагчдын холбоо ТББ-ын тэргүүн

Нарийн бичгийн дарга –Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ төслийн зохицуулагч

_____оОо_____